

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2001 оны 11 дүгээр сарын
22-ны өдөр

Дугаар 615

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дугаар заалт, Засгийн Газрын 2001 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийхэд энэхүү журмыг мөрдлөгө болгон ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг мөрдлөгө болгон биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.ЦЭНДСУГАР/-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн хорооны 1996 оны 56 дугаар "Журам батлах тухай" тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХОРООНЫ ДАРГА

Л.ПҮРЭВДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ЦЭНДСУГАР

Төрийн өмчийн хорооны 2001 оны
615 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ҮЛ ХӨДЛӨХ
ХӨРӨНГӨНД ОРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ, ХҮЛЭЭН АВАХ,
ТООЦОЖ БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээсийн гэрээгээр эзэмшигч нь төсвийн болон хувийн хөрөнгөөр барилга байгууламжийн хийц хэсэг, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах, их засвар хийхийг төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалт гэж үзэн, /цаашид хөрөнгө оруулалт гэх/ энэ хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2.Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, тохижолт, үйлчилгээг сайжруулах, галын аюулгүй ажиллагаа хангах, барилга байгууламжийн урсгал засвар хийхэд зарцуулсан хөрөнгө нь энэ журамд үл хамаарна.

3.Их засварт барилгын дээвэр, тааз, шал, хаалга, цонх, инженерийн шугам сүлжээг иж бүрнээр солих болон эдгээртэй холбогдон үүссэн барилгын засварын ажлыг багтаан ойлгоно.

4.Барилга байгууламжийн гадна дотор заслын ажил, дүүжин тааз, цахилгаан, сантехник, салхивчийн системийн хэсэгчилсэн засвар, угаалга, техник хэрэгслийн эд ангийг солих, тоноглох ажлууд нь урсгал засварт тооцогдоно.

Хоёр. Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих,
хүлээн авах, тооцож баталгаажуулах байгууллага

5. Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах үйл ажиллагааг Төрийн өмчийн хороо /цаашид хороо гэх/ хариуцна.

Гурав. Хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох

6. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч нь хөрөнгө оруулалтын зориулалт, хэмжээ, онцлог шинж чанарыг тусгасан хөрөнгө оруулалт хийх

хүсэлтээ албан бичгээр, тойм зургийг хавсарган /цаашид захиалга гэх/ хороонд ирүүлнэ. Хөрөнгө оруулалтыг хэрхэн тооцох талаар түрээслүүлэгчийн саналыг авч хавсаргана.

7. Төрийн өмчийн хороо захиалгыг 14 хоногийн дотор хянан үзэж, дүгнэлтийг бичгээр гаргана.

8. Хорооны дүгнэлтэд хөрөнгө оруулалтын хэмжээ, хийц, үр өгөөж, зориулалтаа өөрчлөн ажиллахад хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн ашиглах боломжийн талаар тодорхой тусгахын зэрэгцээ тусгай техникийн нөхцөл, холбогдох байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэхийг тодорхой зааж өгнө. Хороо нь хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгохын өмнө түрээслэгчийн эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгийн үнэлгээ шинэчлэн хийлгэсэн байна.

9. Төрийн өмчийн хорооны хурлаар дүгнэлтийг хэлэлцэн хөрөнгө оруулалтын зөвшөөрөл /цаашид зөвшөөрөл гэх/ олгоно.

10. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч нь хорооны дүгнэлтийг баримтлан мэргэжлийн байгууллагаар ажлын зураг, төсөв зохиолгоно. Ажлын зураг төслийг Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн газраар хянуулсан байна.

Дөрөв. Хөрөнгө оруулалтад хяналт тавих, хүлээн авах

11. Хороо нь хөрөнгө оруулалтыг хүлээн авах комиссыг томилж, хөрөнгө оруулалт нь ажлын зураг, төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, ил, далд ажлын актад, гарын үсэг зурж баталгаажуулах, хөрөнгө оруулалтыг хүлээн авах ажлыг зохион байгуулна.

12. Хөрөнгө оруулалтын зардал нь хөрөнгө оруулсан байгууллагын санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдан татвар, аудитын байгууллагаар баталгаажсан байна.

Тав. Хөрөнгө оруулалтыг тооцож баталгаажуулах

13. Энэхүү журмын 6,7,8,9,10,11 дүгээрт заасан баримт бичгийг үндэслэн Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, баталгаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.

14. Баталгаажсан хөрөнгө оруулалтад зохих журмын дагуу жил бүр элэгдэл тооцож байна.

15. Түрээсийн гэрээгээр эзэмшүүлсэн үл хөдлөх хөрөнгийг төр, засгийн эрх бүхий дээд байгууллагын шийдвэрээр өөр байгууллагад шилжүүлэх, хувьчлах эсвэл түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд түрээсийн гэрээг цуцлан элэгдлийг тооцон хасч тогтоосон хөрөнгө оруулалтын дүнг түрээслэгчид нөхөн олгох асуудлыг Төрийн өмчийн хорооны хуралдаанд оруулан шийдвэрлүүлнэ.

16. Энэхүү журмыг зөрчин дур мэдэн хийгдсэн бичиг баримтын бүрдэлгүй хөрөнгө оруулалтыг төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт гэж тооцохгүй.

Зургаа. Журам батлагдахаас өмнөх хөрөнгө оруулалтыг тооцох

17. Энэхүү журам батлагдахаас өмнө хийгдсэн хөрөнгө оруулалтыг дор дурдсан зайлшгүй бүрдүүлэх баримт бичгүүдийг үндэслэн жинхэнэ гүйцэтгэлтэй нь тулган үзэж тогтооно.

а / Хөрөнгө оруулалт хийх тухай түрээслэгч, түрээслүүлэгч талуудаас байгуулж, эрх бүхий хүмүүс баталсан албан ёсны гэрээ, протокол,

б / Хөрөнгө оруулалт хийх батлагдсан зураг, төсөл,

в / Хөрөнгө оруулалтын ажлыг нэр төрөл, зүйл бүрээр тусган хийсэн албан ёсны төсөв,

г / Хөрөнгө оруулалт хийснийг түрээслэгч, түрээслүүлэгч талууд үзэж тогтоосон акт,

д / Батлагдсан зураг, төсөл, төсвийн дагуу хийсэн санхүүгийн төлбөр тооцооны баримтууд,

е / Татварын байгууллагаас хянаж баталгаажуулсан хөрөнгө оруулалтыг тусгасан санхүүгийн тайлан тэнцэл,

ж / Хөрөнгө оруулалтын ажлыг хариуцан гүйцэтгэсэн байгууллагатай хийсэн гэрээ хэлцэл, түүний биелэлтийг тооцсон акт баримтууд,

Долоо. Журам батлагдахаас өмнөх хөрөнгө оруулалтыг баталгаажуулах

18. Энэхүү журмын 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтад хувьчлалын гэрээ цуцлагдснаар төрийн өмчид буцаан авч буй

үл хөдлөх хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг багтаан ойлгох бөгөөд Төрийн өмчийн хорооны хурлаар хэлэлцэн баталгаажуулна.

Найм. Бусад

19. Хөрөнгө оруулалт нь үр дүнтэй, тухайн барилгын ашиглалтын хугацаатай харьцуулахад тохирохуйц болж чадсаныг мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тодорхойлогдсон байвал хөрөнгө оруулалтын үнэлгээ тухайн төрийн өмчийн барилга байгууламжийн үнийн 51 хувьтай тэнцүү буюу түүнээс давсан тохиолдолд уг өмчийг түрээслэгч байгууллагын саналыг харгалзан хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгохын өмнө шинэчлэн тогтоосон үнээр худалдах асуудлыг Төрийн өмчийн хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

21. Захиалга, дүгнэлт, зөвшөөрөл, ажлын зураг, төсөв, ил, далд ажлын акт, төсвийн тооцоо, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хүлээн авсан комиссын актыг хорооны архивт хадгална.

----- о О о -----